



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон нийт 56,784,300.00 (тавин зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 3 автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь удаа) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000053

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн
46 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТГИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг (төгрөг)	2019 оны 292 дугаар тогтоолоор	Шинэчлэн тогтоосон үнэ
1	ПАЗ 32054, автобус, 02-31 ОРА, 50001989	2005	376,000	24,288,500.00	24,288,500.00	-	3,000,000.00	1,800,000.00
2	ПАЗ 32054, автобус, 22-26 ОРА, 2380831	1998	387,000	8,202,300.00	8,202,300.00	-	3,000,000.00	1,800,000.00
3	ЗИЛ-130, 02-32 ОРА, 50001905	2005	366,500	24,293,500.00	24,293,500.00	-	3,000,000.00	1,800,000.00
Нийт дүн				56,784,300.00	56,784,300.00	-	9,000,000.00	5,400,000.00
				(тавин зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга гурван зуун)		(есөн сая)		(таван сая дөрвөн зуун)